

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/186/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/74
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020283

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>42,134,687.82</u>	<u>114,772,463.28</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	10,577,981.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	10,577,981.00
3121	Төгрөг	-	10,577,981.00
31211	Төрийн сангийн харилцах	-	10,577,981.00
33	АВЛАГА	2,687,703.74	54,031,025.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	582,384.00	355,825.00
335	Бусад авлага	2,105,319.74	53,675,200.00
3351	Байгууллагаас авах авлага	2,094,619.74	53,664,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,700.00	10,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,446,984.08	50,163,457.28
351	Түүхий эд материал	36,500,024.08	45,198,027.28
35110	Тусгай зориулалттай материал	21,593,494.27	15,041,542.72
35130	Эм боох материал	14,906,529.81	30,156,484.56
354	Хангамжийн материал	2,946,960.00	4,965,430.00
35410	Бичиг хэргийн материал	171,600.00	249,600.00
35420	Аж ахуйн материал	1,078,900.00	1,371,600.00
35450	Барилгын засварын материал	35,500.00	35,500.00
35460	Хүнсний материал	1,660,960.00	3,308,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>439,183,013.47</u>	<u>427,269,166.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	439,183,013.47	427,269,166.81
392	Биет хөрөнгө	431,631,388.68	419,741,375.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	323,862,330.00	323,862,330.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,496,915.05)	(15,401,007.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,080,000.00	70,080,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,280,778.02)	(42,444,000.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,885,321.90	86,130,201.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,872,002.69)	(12,578,241.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,630,905.00	14,023,738.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,177,472.46)	(3,931,645.48)
393	Биет бус хөрөнгө	7,551,624.79	7,527,791.43
39301	Программ хангамж	1,285,000.00	1,265,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(859,375.21)	(863,208.57)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,126,000.00	7,126,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>481,317,701.29</u>	<u>542,041,630.09</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>599,904.00</u>	<u>16,981,783.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	599,904.00	16,981,783.00
413	Өглөг	599,904.00	16,981,783.00
4136	Бусад өглөг	599,904.00	16,981,783.00
41361	Байгууллагад төлөх өглөг	599,904.00	16,981,783.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>480,717,797.29</u>	<u>525,059,847.09</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	480,717,797.29	525,059,847.09

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,404,778.19	191,404,778.19
51101	Өмч: - төрийн	191,404,778.19	191,404,778.19
512	Хуримтлагдсан үр дүн	69,383,494.05	113,774,274.85
51210	Өмнөх үеийн үр дүн	21,587,071.35	69,432,225.05
51220	Тайлант үеийн үр дүн	47,796,422.70	44,342,049.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,929,525.05	219,880,794.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>481,317,701.29</u>	<u>542,041,630.09</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	434,269,262.80	758,249,285.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,964,009.80	227,344,584.22
120	Нийтлэг татварын бус орлого	56,964,009.80	227,344,584.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,964,009.80	227,344,584.22
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,964,009.80	227,344,584.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,305,253.00	530,904,701.24
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	327,826,700.00	360,753,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	327,826,700.00	360,753,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,278,883.00	133,374,196.24
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,278,883.00	133,374,196.24
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,023,500.00	19,467,335.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,023,500.00	19,467,335.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,176,170.00	17,309,570.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,176,170.00	17,309,570.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	386,472,840.10	665,482,993.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,472,840.10	665,482,993.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	372,752,343.10	664,474,993.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,582,146.00	283,184,169.00
210101	Үндсэн цалин	175,525,846.00	242,565,497.00
210102	Нэмэгдэл	64,529,400.00	36,205,672.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,700,000.00	4,413,000.00
210104	Урамшуулал	16,826,900.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,194,773.00	35,791,791.00
210201	Тэтгэврийн даатгал	21,640,691.00	25,172,493.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,638,521.00	2,724,505.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,110,817.00	2,179,605.00
210204	Ажилгүйдлийн даатгал	527,708.00	519,562.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,277,036.00	5,195,626.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,804,664.00	17,777,431.00
210301	Гэрэл, цахилгаан	2,229,754.00	2,020,187.00
210302	Түлш, халаалт	13,244,910.00	15,317,244.00
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	440,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,089,698.80	45,746,439.20
210401	Бичиг хэрэг	1,557,100.00	2,468,050.00
210402	Тээвэр, шатахуун	13,939,698.80	26,822,031.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,556,400.00	801,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	911,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,916,500.00	4,470,383.00
210408	Бараа материал акталсны зардал		10,273,225.00

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	33,309,433.56	238,848,068.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,613,408.56	218,816,537.80
210502	Хоол, хүнс	7,696,025.00	20,031,531.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,000.00	800,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		800,100.00
210604	Урсгал засвар	38,000.00	
2107	Томилолт, зочны зардал	1,514,100.00	412,000.00
210702	Дотоод албан томилолт	1,514,100.00	412,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	615,300.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,800.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	149,500.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,604,227.74	41,914,994.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,627,700.00	16,272,307.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,976,527.74	25,642,687.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,720,497.00	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	599,940.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	599,940.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,120,557.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,120,557.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	47,796,422.70	92,766,291.59
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	48,424,241.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		48,424,241.79
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(48,424,241.79)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	47,796,422.70	44,342,049.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,404,778.19	219,929,525.05	21,587,071.35	432,921,374.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,404,778.19	219,929,525.05	21,587,071.35	432,921,374.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			47,796,422.70	47,796,422.70
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,404,778.19	219,929,525.05	69,383,494.05	480,717,797.29
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,404,778.19	219,929,525.05	117,179,916.75	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			48,731.00	48,731.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,404,778.19	219,929,525.05	69,432,225.05	480,766,528.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			44,342,049.80	44,342,049.80
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,404,778.19	219,929,525.05	113,774,274.85	525,108,578.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	377,305,253.00	498,357,660.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	377,305,253.00	498,357,660.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	327,826,700.00	360,753,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	327,826,700.00	360,753,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,278,883.00	100,827,155.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,278,883.00	100,827,155.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17,023,500.00	19,467,335.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,023,500.00	19,467,335.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	26,176,170.00	17,309,570.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,176,170.00	17,309,570.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	375,399,756.00	485,206,579.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,399,756.00	485,206,579.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,679,259.00	484,198,579.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,582,146.00	282,716,853.00
210101	Үндсэн цалин	175,525,846.00	155,972,295.50
210102	Нэмэгдэл	64,529,400.00	94,281,946.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,700,000.00	3,852,000.00
210104	Урамшуулал	16,826,900.00	28,610,611.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,038,387.00	36,032,548.00
210201	Тэтгэврийн даатгал	21,405,987.00	26,427,966.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,900.00	2,461,560.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,126,300.00	1,969,247.91
210204	Ажилгүйдлийн даатгал	532,500.00	470,340.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,315,700.00	4,703,431.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,224,760.00	18,267,335.00
210301	Гэрэл, цахилгаан	2,249,754.00	2,020,187.00
210302	Түлш, халаалт	12,645,006.00	15,917,148.00
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	330,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,816,980.00	26,930,100.00
210401	Бичиг хэрэг	999,700.00	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,823,880.00	22,975,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,493,400.00	1,455,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	21,962,883.00	85,537,610.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,857,383.00	67,718,700.00
210502	Хоол, хүнс	7,105,500.00	17,818,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,973,303.00	4,226,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	574,503.00	2,400,000.00

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,200,000.00	626,900.00
210604	Урсгал засвар	1,198,800.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,514,100.00	1,788,394.00
210702	Дотоод албан томилолт	1,514,100.00	1,788,394.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,574,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,992,700.00	28,698,839.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,992,700.00	28,698,839.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,720,497.00	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,008,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	599,940.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	599,940.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,120,557.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,120,557.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,905,497.00</u>	<u>13,151,081.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,905,497.00	2,573,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,905,497.00	2,573,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,905,497.00	2,573,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,905,497.00	2,573,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,905,497.00)</u>	<u>(2,573,100.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	10,577,981.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,577,981.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	408,992,900.00	386,952,524.00	22,040,376.00	94.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	408,992,900.00	386,952,524.00	22,040,376.00	94.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408,992,900.00	386,952,524.00	22,040,376.00	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	289,481,000.00	272,144,947.00	17,336,053.00	94.0
210101	Үндсэн цалин	181,012,100.00	155,972,295.50	25,039,804.50	86.2
210102	Нэмэгдэл	76,025,100.00	83,710,040.00	(7,684,940.00)	110.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,292,000.00	3,852,000.00	1,440,000.00	72.8
210104	Урамшуулал	27,151,800.00	28,610,611.50	(1,458,811.50)	105.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,079,900.00	36,032,548.00	3,047,352.00	92.2
210201	Тэтгэврийн даатгал	27,500,700.00	26,427,966.98	1,072,733.02	96.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,894,800.00	2,461,560.90	433,239.10	85.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,315,800.00	1,969,247.91	346,552.09	85.0
210204	Ажилгүйдлийн даатгал	579,000.00	470,340.93	108,659.07	81.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,789,600.00	4,703,431.28	1,086,168.72	81.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,667,800.00	18,267,335.00	1,400,465.00	92.9
210301	Гэрэл, цахилгаан	2,848,300.00	2,020,187.00	828,113.00	70.9
210302	Түлш, халаалт	16,489,500.00	15,917,148.00	572,352.00	96.5
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	330,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,975,000.00	22,930,100.00	44,900.00	99.8
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	18,975,000.00	18,975,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,455,100.00	44,900.00	97.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	22,889,200.00	22,889,200.00	-	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,889,200.00	13,889,200.00	-	100.0
210502	Хоол, хүнс	9,000,000.00	9,000,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,800,000.00	6,800,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,400,000.00	2,400,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,200,000.00	3,200,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,788,394.00	211,606.00	89.4
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,788,394.00	211,606.00	89.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,100,000.00	6,100,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,100,000.00	6,100,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	408,992,900.00	397,530,505.00	11,462,395.00	97.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	360,753,600.00	360,753,600.00	-	100.0

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	360,753,600.00	360,753,600.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		20,867,800.00	19,467,335.00	1,400,465.00	93.3
132001	Орон нутгийн төсвөөс	20,867,800.00	19,467,335.00	1,400,465.00	93.3
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		27,371,500.00	17,309,570.00	10,061,930.00	63.2
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,371,500.00	17,309,570.00	10,061,930.00	63.2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО				
		20.00	20.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,827,155.00	100,827,155.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,827,155.00	100,827,155.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,819,155.00	99,819,155.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,571,906.00	10,571,906.00
210102	Нэмэгдэл	10,571,906.00	10,571,906.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,000,000.00	4,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,000,000.00
2105	Нормативт зардал	62,648,410.00	62,648,410.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,829,500.00	53,829,500.00
210502	Хоол, хүнс	8,818,910.00	8,818,910.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,598,839.00	22,598,839.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,598,839.00	22,598,839.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,000.00	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,008,000.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00	1,008,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	100,827,155.00	100,827,155.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,827,155.00	100,827,155.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,827,155.00	100,827,155.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НДШ төлөлтийн тайлан, татварын тайланг нэн зөв бэлтгэх, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал, Э.Батчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй харилцааг зохицуулах, хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, эмчилгээ үйлчилгээний чанар бүтээмжийг дээшлүүлэхийг эрхэм зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/03 дугаар тушаалаар дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Тайлант онд дотоод хяналтын баг нь түргэн тусламжийн шатахууны олголт, зарцуулалт, жолоочийн замын хуудас, шилэн дансны хөтлөлтийн талаар хяналт шалгалт хийж ажилласан байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг.

Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 408,992.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,134.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,601.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Гүүксофт” ХХК-ний “Dynamic” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 408,992.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 97.2 хувийн 397,530.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 100,827.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 498,357.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 57,849.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,223.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 80.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 62,153.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,573.1 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 11,239.9 мянган төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэн 48,340.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 155,917.8 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 154,845.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 299,969.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/71 дугаар тогтоолоор 9,724.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан.

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэл 54,031.0 мянган төгрөг, өглөг 16,981.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь ЭМДЕГ-аас авах авлага, аж ахуй нэгж байгууллагатай холбоотой эмийн өглөг байна. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн дансанд 10,578.0 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 50,163.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 427,269.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	10,578.0	10,577.98
Авлага	2,687.7	54,031.0	51,343.33
Урьдчилгаа	-		-
Бараа материал	39,447.0	50,163.5	10,716.47
Үндсэн хөрөнгө	439,183.0	427,269.2	(11,913.84)
Нийт хөрөнгө	481,317.7	542,041.6	60,723.94
Өр төлбөр	599.9	16,981.8	16,381.89
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	480,717.8	525,059.8	44,342.05
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	481,317.7	542,041.6	60,723.94

Бараа материалын дансны үлдэгдэл 50,163.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 10,716.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 427,269.2 мянган төгрөг болж 11,913.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 525,059.8 мянган төгрөг болж 44,342.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 408,992.9 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 408,992.9 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 408,992.9 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 360,753.6 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 19,467.3 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 17,309.6 мянган төгрөгийн, нийт 397,530.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 386,952.5 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 10,578.0 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 386,952.5 мянган төгрөг буюу 94.6 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 100,827.2 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 99,819.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,008.0 мянган төгрөгийг зарцуулж зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлан болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус Эрүүл мэндийн төв нь Ковид-19-ын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж, 2021 онд коронавирусын батлагдсан тохиолдол 285 гарснаас Аймгийн нэгдсэн эмнэлэгт 54 тохиолдол, сумын Эрүүл мэндийн төвд 136 тохиолдол, гэрийн эмчилгээнд 95 тохиолдлыг хамруулан эмчилж, хариу арга хэмжээний баг ойрын болон дам хавьтлын судалгааг гарган, давхардсан тоогоор PCR-ийн шинжилгээнд 1,536 сорьц тээвэрлэж, түргэвчилсэн оношлуураар 956 шинжилгээг хийсэн. Эрүүл мэндийн даатгалын сангаас Коронавируст халдвар /Ковид-19/ -ын тусламж үйлчилгээний санхүүжилтийг хувийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай эм, эмийн нөөц бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт, өвчтөний хоол, улаан бүсэд ажилласан эмч, ажилчдын цалин зэрэгт бүрэн зарцуулж, уг үйл ажиллагааг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансанд 62,153.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,573.1 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 11,239.9 мянган төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэн 48,340.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 155,917.8 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 154,845.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 299,969.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар

сарын 25-ны өдрийн А/71 дугаар тогтоолоор 9,724.9 мянган төгрөгийн бараа материалыг акталсан.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 120 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 26 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1 алдаа зөрчил тайлант онд давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,755.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 1 алдааг залруулж, 310.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 1,444.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 1 алдааг залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланг 2 оноор зэрэгцүүлж тайлагнаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 310.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. 2021 оны 6 сард 19 албан хаагчдад вакцины урамшуулалт цалин олгоходоо НДШ-ийг суутган тооцолгүй, зөвхөн ХХОАТ-ыг суутган тооцсоны улмаас гарт олгох урамшуулалт цалинг 310.1 мянган төгрөгөөр илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 120 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 26 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг бодитой гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацааны цалингийн цэсээр бодогдсон цалин, НДШ төлөлтийн тайлангийн мэдээг тулган шалгахад 1 албан хаагчийн цалинг хөлсийг 1,445.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэнтэй нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв бэлтгэн тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв	4	1,755.1	1	-	1	310.1	1	-	1	1,445.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn